



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 1/3до

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.
2. Магадлан итгэмжлэлийн хугацаа тасарч сунгагдаж буй эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэл эхлэх хугацааг 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн тооцугай.
3. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 9 дүгээр хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/ -д тус тус үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай

САЙД



С.ЭНХБОЛД

141221564

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 06
дугаар сарын 16 - ны өдрийн А/Золд
дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн Дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	АШУҮИС, Монгол Анагаах Ухааны Төв Эмнэлгийн "Эрхэс" сувилал	182/2022	2 жил	2022.06.13	2024.06.13
2.	"Зоонозын өвчин судлалын үндэсний төв"	183/2022	3 жил	2022.06.25	2025.06.25
3.	"Их шүүдэргэнэ импорт" ХХК-ийн "Медвик" эмнэлэг	184/2022	1 жил	2022.06.13	2023.06.13
4.	"Сити энержи" ХХК-ийн "Улаанбаатар Мед" эмнэлэг	185/2022	2 жил	2022.06.16	2024.06.16
5.	"Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төв"	186/2022	2 жил	2022.06.22	2024.06.22
6.	"Чимэжүд" ХХК-ийн эмнэлэг	187/2022	1 жил	2022.06.13	2023.06.13
7.	Архангай аймаг, "Хангай" сумын эрүүл мэндийн төв	188/2022	2 жил	2022.06.13	2024.06.13
8.	Архангай аймаг, "Тариат" сумын эрүүл мэндийн төв	189/2022	1 жил	2022.06.13	2023.06.13
9.	Орхон аймаг, "ЗБЗ амьдрал бэлэглэгч" ХХК-ийн "Мөнхийн үйлс" эмнэлэг	190/2022	2 жил	2022.06.14	2024.06.14
10.	Төв аймаг, "Өрмөн-уул групп" ХХК-ийн "Хайрын билэг-2" сувилал	191/2022	3 жил	2022.06.14	2025.06.14

оо0оо